



НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР



АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР - 2025

Улаанбаатар хот
2026

ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭН БОЛОВСРУУЛСАН:

Ц.Соёл-Эрдэнэ

Нийслэлийн Статистикийн газрын эдийн засгийн
статистикийн хэлтсийн ахлах мэргэлжин

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

Э.Зоригбат

Нийслэлийн Статистикийн газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ө.Нямжаргал

Нийслэлийн Статистикийн газрын эдийн засгийн
статистикийн хэлтсийн дарга

НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот

Нийслэлийн засаг захиргааны II байр

Утас: (976-51)-328787, (976-51)-322783

Факс:

Цахим хуудас: www.ubstat.mn



Имэйл:



НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР

ulanbaatar@nso.mn

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА – 2025

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	5
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	6
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	7
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	8
ХАМРАХ ХҮРЭЭ	9
I. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	12
I.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСАГТ ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ	12
I.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, АЖИЛЛАГЧИД	13
I.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ	18
I.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛАЛТ	19
II. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ	21
II.1 НҮҮРС ОЛБОРЛОЛТ	21
II.2 ГАЗРЫН ТОС ОЛБОРЛОЛТ	22
II.3 БУСАД АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЛТ	22
III. БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ	23
II.1 ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН, УНДАА ҮЙЛДВЭРЛЭЛ	23
III.1.1 Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	23
III.1.2 Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	23
III.1.3 Гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	24
III.1.4 Ундаа үйлдвэрлэл	24
II.2 ТӨМӨРЛӨГ БУС ЭРДЭС БОДИСООР ХИЙСЭН БҮТЭЭГ ДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ	25
II.3 НООС, НООСОН БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ	25
II.4 ҮНДСЭН ЭМИЙН БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ БОЛОН ЭМИЙН БЭЛДМЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ	26
II.5 АРЬС, АРЬСАН БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ	26
II.6 ХУВЦАС ҮЙЛДВЭРЛЭЛ	26
IV ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ, УС ХАНГАМЖ, СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	27
IV.1 ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ ҮЙЛДВЭРЛЭЛ	27
IV.2 ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ ҮЙЛДВЭРЛЭЛ	27
IV.3 УС ХАНГАМЖ, СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ, ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	28
V ДҮГНЭЛТ	29
VI. ХАВСРАЛТ	30

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, дүүргээр, жил бүрийн эцэст	13
ХҮСНЭГТ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧИД, дэд салбар, насны бүлгээр, 2025 он	16
ХҮСНЭГТ 3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧИД, дэд салбар, хүйсээр, жил бүрийн эцэст	17
ХҮСНЭГТ 4. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар	18
ХҮСНЭГТ 5. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛАЛТ, дэд салбараар	19
ХҮСНЭГТ 6. НҮҮРС ОЛБОРЛОЛТЫН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ	21
ХҮСНЭГТ 7. ГАЗРЫН ТОС ОЛБОРЛОЛТЫН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ.....	22
ХҮСНЭГТ 8. БУСАД АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЛТ	22
ХҮСНЭГТ 9. БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН БҮТЭЦ, дэд салбар	23
ХҮСНЭГТ 10. СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, гол нэр төрлөөр	23
ХҮСНЭГТ 11. ГУРИЛАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ.....	24
ХҮСНЭГТ 12. УНДАА, СОГТУУРУУЛАХ УНДАА ҮЙЛДВЭРЛЭЛ.....	25
ХҮСНЭГТ 13. ТӨМӨРЛӨГ БУС ЭРДЭС БОДИСООР ХИЙСЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрлөөр, жил бүрийн эцэст.....	25
ХҮСНЭГТ 14. БОЛОВСРУУЛСАН НООС, НООЛУУР, НЭХМЭЛ ЭДЛЭЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрлөөр	25
ХҮСНЭГТ 15. ҮНДСЭН ЭМИЙН БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ЭМИЙН БЭЛДМЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, гол нэр төрлөөр.....	26
ХҮСНЭГТ 16. АРЬС ШИРЭН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, гол нэр төрлөөр	26
ХҮСНЭГТ 17. ХУВЦАС ҮЙЛДВЭРЛЭЛ.....	26
ХҮСНЭГТ 18. ЦАХИЛГААН, ХИЙ, УУР АГААРЖУУЛАЛТЫН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ.....	27
ХҮСНЭГТ 19. УС ХАНГАМЖ, СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ	28

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ САЛБАРЫН БҮТЭЦ	12
ЗУРАГ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГТ ДЭД САЛБАРЫН ЭЗЛЭХ ХУВЬ	12
ЗУРАГ 3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, 2025 он, дэд салбар, хувиар	13
ЗУРАГ 4. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, дүүргээр, 2025 он	14
ЗУРАГ 5. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧИД, дэд салбар.....	15
ЗУРАГ 6. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧДЫН ТОО, аймаг, нийслэлээр, 2025 он, мянган хүнээр.....	15
ЗУРАГ 7. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧИД, дэд салбар, жил бүрийн эцэст	16
ЗУРАГ 8. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БҮТЭЦ, дэд салбараар	18
ЗУРАГ 9. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БОРЛУУЛАЛТ, дүүргээр, 2025 он	20
ЗУРАГ 10. ХҮРЭН, ЧУЛУУН НҮҮРСНИЙ ОЛБОРЛОЛТ	21
ЗУРАГ 11. ГУРИЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрөл	24
ЗУРАГ 12. ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ ХЭРЭГЛЭГЧДИЙН ТОО, 2025 он, аймаг, нийслэлээр.....	27

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн

ТЭМДЭГЛЭГЭЭ

- * Урьдчилсан гүйцэтгэл
- ** Дахин их
- ! Харьцуулагдахгүй

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

ОЙЛГОЛТ	ТОДОРХОЙЛОЛТ
Нийт үйлдвэрлэл	Тайлант хугацаанд шинээр үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний нийт дүн (тухайн оны үнээр)-г хэлнэ.
Завсрын хэрэглээ	Үйлдвэрлэл, үйлчилгээний явцад орц болж зарцуулагдсан бүтээгдэхүүний зардал (худалдан авсан барааны өртгөөс жилийн нөөцийн өөрчлөлтийг хасна) болон үйлчилгээний төлбөрийг хэлнэ.
Нэмэгдэл өртөг	Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хассан дүнг хэлнэ. Нийт үйлдвэрлэлийн үндсэн үнээр, завсрын хэрэглээг худалдан авагчийн үнээр үнэлнэ.
Бүтээгдэхүүний борлуулалт	Тайлант хугацаанд худалдсан буюу бусдад зориулж гүйцэтгэсэн ажил үйлчилгээг хэлнэ. Нийт борлуулалтад тухайн үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн ажил үйлчилгээний борлуулалтад орно. Хэрэв захиалагч бүтээгдэхүүнийхээ төлбөрийг урьдчилан төлсөн бол уг бүтээгдэхүүнийг борлуулагдсан гэж үзнэ.
Аж үйлдвэрийн борлуулалт	Зөвхөн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг хамруулна. Энд үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн, үйлчилгээ, үндсэн хөрөнгө, түүхий эд материал зэргийн худалдан борлуулсан хэмжээг хамруулахгүй.
Үндсэн үнэ	Аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлд гарсан зардал, ашгаа тооцон багтаасан үнийг үндсэн үнэ гэнэ. Үндсэн үнэд татварыг оруулж тооцохгүй ба татаасыг оруулж тооцно.
Үйлдвэрлэгчийн үнэ	Үндсэн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг бараа, үйлчилгээний татвар (нэмэгдсэн өртгийн татвараас бусад) болон тээвэр, худалдааны нэмэгдлүүдийг нэмж, татаасыг хасаж тооцсон үнийг хэлнэ.
Зах зээлийн үнэ буюу худалдан авагчийн үнэ	Үйлдвэрлэгчийн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг нэмэгдэл өртгийн албан татварыг нэмж тооцсон үнийг хэлнэ.
Бүтээгдэхүүн	Үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон бараа, үйлчилгээг хэлнэ.
Хагас боловсруулсан бүтээгдэхүүн (дуусаагүй үйлдвэрлэл)	Зах зээлд нийлүүлэхэд үйлдвэрлэл нь хараахан дуусаагүй бэлэн бус бүтээгдэхүүнийг хэлнэ.
Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Тайлант хугацаанд үйлдвэрлэсэн салбарын үйлдвэрлэлийг төлөөлөхүйц бүтээгдэхүүнийг хэлнэ.

ОЙЛГОЛТ	ТОДОРХОЙЛОЛТ
Ажиллагч	Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн статуст хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Ажил эрхлэлттэй холбоотой ойлголт, тодорхойлолт нь хөдөлмөрийн статистикт ашигладаг ойлголт, тодорхойлолттой адил байна.
Ажилласан цаг	Тайлант хугацаанд ажиллагчид (цалин хөлстэй ажиллагч болон цалин хөлсгүй ажиллагч)-ийн ажилласан цагийг хэлнэ.
Үйлдвэрлэлийн индекс	Үнийн өөрчлөлтийн нөлөөллийг арилгасан биет хэмжээний өөрчлөлтийг илэрхийлэх индексийг хэлнэ.
Улирлын нөлөөллийг арилгах	Хугацааны цуваан дахь улирлын шинж чанартай нөлөөллийг арилгах статистик арга юм.
Цахилгааны тэнцэл	<p>Үйлдвэрлэсэн, импортоор авсан цахилгаан эрчим хүчний нийлбэртэй тэнцүү байна. Цахилгааны тэнцлийг биет хэмжээгээр тооцно.</p> <p>Үйлдвэрлэл + Импорт = Дотоод хэрэглээ + Түгээлт + Шугамын болон түгээлтийн алдагдал + Экспорт</p>
Дулааны тэнцэл	<p>Үйлдвэрлэсэн, импортоор авсан дулааны эрчим хүчний нийлбэртэй тэнцүү байна. Дулааны тэнцлийг биет хэмжээ (мян.Гкал)-гээр тооцно.</p> <p>Үйлдвэрлэл + Импорт = Дотоод хэрэглээ + Түгээлт + Шугамын болон түгээлтийн алдагдал + Экспорт</p>
Нүүрсний тэнцэл	<p>Оны эхний үлдэгдэл, тухайн жилд олборлосон нүүрсний нийлбэртэй тэнцүү байна. Олборлосон нүүрсний тэнцлийг биет хэмжээгээр тооцно.</p> <p>Оны эхний үлдэгдэл + Олборлолт = Борлуулалт + Дахин боловсруулах үйлдвэрт өгсөн нүүрс + Экспорт + Тээвэрлэх, хадгалах үеийн хорогдол + Оны эцсийн үлдэгдэл</p>

ХАМРАХ ХҮРЭЭ

Аж үйлдвэрийн салбарын сар, жилийн мэдээг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC-4.0)-ын дагуу уул уурхай, олборлолт, боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан, хий, уур, агааржуулалт, ус хангамж; сувагжилтын систем, хог, хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа гэсэн 4 салбарыг хамруулан авч үздэг.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг тооцох мэдээллийн эх үүсвэр нь бизнес регистрийн санд бүртгэлтэй аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны тайлан болон холбогдох захиргааны статистик мэдээлэл болно. Мэдээллийг сарын болон жилийн давтамжтайгаар цуглуулж, холбогдох тооцооллыг хийдэг.

САРЫН ДАВТАМЖТАЙ:

“Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ”-ний маягтаар аж үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудын гүйцэтгэлийг биет хэмжээ, үнийн дүнгээр тухайн сарын болон жилийн өссөн дүнг цуглуулдаг. Мөн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, гадаад, дотоодын борлуулалт, гол нэрийн бүтээгдэхүүний тухайн сард борлогдоогүй үлдэгдэл, ажиллагчдын тоо, ажилласан цаг зэрэг үзүүлэлтийг тооцдог.

ЖИЛИЙН ДАВТАМЖТАЙ:

“Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээ”, “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны хураангуй мэдээ” гэсэн маягтаар тухайн ААНБ-ын орлого, зарлага, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулан нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээ, аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийг тооцож байна. “Цахилгаан эрчим хүчний баланс”, “Дулааны эрчим хүчний баланс” маягтаар цахилгаан, дулааны станцуудаас мэдээллийг цуглуулдаг бөгөөд үйлдвэрлэсэн болон импортоор авсан цахилгаан эрчим хүчний хэмжээ, цахилгаан станцын дотоод хэрэглээ, түгээлтийн болон шугамын алдагдал, хуваарилалт зэрэг үзүүлэлтээр цахилгаан, дулааны эрчим хүчний тэнцлийг байгуулдаг. Харин “Олборлосон нүүрсний баланс” маягтын дагуу нүүрсний уурхайгаас олборлосон нүүрсний хэмжээ, экспорт, тээвэрлэх, хадгалах үеийн хорогдол, хэрэглээний биет хэмжээг авч, нүүрсний тэнцлийг байгуулан тооцож байна.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод аж үйлдвэрийн салбар ХХ зууны эхэн үеэс хөгжиж эхэлсэн бөгөөд 1921 оны Ардын хувьсгалын дараа төрөөс үйлдвэржилтийг дэмжих бодлого хэрэгжүүлснээр эрчимжсэн. Үүсэл:

- 1920-иод онд арьс шир боловсруулах, ноос угаах, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах зэрэг жижиг үйлдвэрүүд байгуулагдсан.
- 1930-аад оноос улсын үйлдвэрүүд байгуулагдаж, гар үйлдвэрлэлээс машинт үйлдвэрлэлд шилжих суурь тавигдсан.
- Зөвлөлт Холбоот Улсын техник, санхүүгийн тусламжаар аж үйлдвэрийн анхны томоохон үйлдвэрүүд байгуулагдсан.

ХӨГЖИЛ:

- 1950–1980-аад онд аж үйлдвэр эрчимтэй хөгжиж, нийслэлд ноос ноолуур, арьс шир, хүнс, барилгын материал, эрчим хүчний үйлдвэрүүд төвлөрсөн.
- Говь ХК, Улаанбаатар хивс ХК зэрэг томоохон үйлдвэрүүд байгуулагдаж, дотоодын хэрэгцээг хангахаас гадна экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн.
- Дулааны цахилгаан станц №4 зэрэг эрчим хүчний байгууллагууд үйлдвэрлэлийн өсөлтийг дэмжсэн.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН АЖИЛЧДЫН ТОО, ДУНДАЖ ЦАЛИН,
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО
2025 ОН

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, дэд салбараар



Усан хангамж,
сувагжилтийн систем,
хог хаягдал зайлуулах

114



Уул уурхай
олборлолт

1 051



Боловсруулах
үйлдвэр

4 944




Цахилгаан, хий,
уур, агааржуулалт

59

15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧДЫН ТОО, дэд салбараар, хүн

БҮГД



АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН,
дэд салбараар, мянган төгрөг

БҮГД




I. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

I.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСАГТ ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Нийслэлийн дотоодын нийт бүтээгдэхүүн (үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2025 онд оны үнээр 62.8 их наяд төгрөг хүрч, өмнөх оноос 5.9 (10.3%) их наяд төгрөгөөр өссөн байна. Аж үйлдвэрийн салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүний 35.8 хувийг (уул уурхай, олборлолтын салбар 26.6 хувь, боловсруулах

үйлдвэрлэл 6.7 хувь, цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамжийн салбар 2.5 хувь, ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар) эзэлж байна.


ЗУРАГ 1. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ САЛБАРЫН БҮТЭЦ



Аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг оны үнээр 22.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 2.2 (10.9%) их төгрөгөөр өссөн байна. Уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 2025 онд 16.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.1 (7.1%) их наяд төгрөг, боловсруулах салбарын нэмэгдэл өртөг 4.3 их наяд төгрөг болж, өмнөх оноос 718.0 (20.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Аж үйлдвэрийн

салбарын нэмэгдэл өртөгт уул уурхай, олборлолтын салбар 74.4 хувийг, боловсруулах салбар 19.0 хувийг, цахилгаан, хий, уур, агааржуулалт, ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар 6.6 хувийг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГТ ДЭД САЛБАРЫН ЭЗЛЭХ ХУВЬ



* урьдчилсан гүйцэтгэл


I.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, АЖИЛЛАГЧИД

Статистикийн бизнес регистрийн санд 2025 онд Нийслэлийн хэмжээнд 188.4 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 81.7 (43.3%) мянга нь үйл ажиллагаа явуулж байна. Аж үйлдвэрийн салбарт 2025 онд 13.1 мянган ААНБ бүртгэлтэй байгаагаас 6.2 (47.0%) мянган нь үйл ажиллагаа явуулж байна. Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа нийт ААНБ-ын 7.6 хувь нь аж үйлдвэрийн салбарт байна. Аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо өмнөх оноос 215 (3.6%) ААНБ-аар өссөн байна. Үүнд боловсруулах

салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо 464 (6.7%) ААНБ-аар, уул уурхай, олборлолтын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо 28 (2.7%) ААНБ-аар, боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо 184 (3.9%) ААНБ-аар, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ тоо 3 (2.7%) ААНБ-аар тус тус өссөн байна.

ЗУРАГ 3.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, 2025 он, дэд салбар, хувиар



- Уул уурхай, олборлолт
- Боловсруулах үйлдвэрлэл
- Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж
- Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа

Аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нийт ААНБ-ын 4944 (80.2%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 1051 (17.0%) нь уул уурхай, олборлолтын салбарт, 59 (1.0%) нь цахилгаан, хий, уур, агааржуулалтын

салбарт, 114 (1.8%) нь ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарт байна.

ХҮСНЭГТ 1.


АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, ДҮҮРГЭЭР, ЖИЛ БҮРИЙН ЭЦЭСТ

Дүүрэг	2021	2022	2023	2024	2025
	Тоо				
Нийт дүн	12 662	13 551	12 619	13 534	13 130
Багануур	82	85	87	89	89
Багахангай	19	19	18	18	16
Баянгол	2 461	2 591	2 365	2 516	2 414
Баянзүрх	2 920	3 140	2 938	3 173	3 045
Налайх	156	169	156	166	175
Сонгинохайрхан	1 884	2 052	1 837	1 977	1 877
Сүхбаатар	2 136	2 244	2 110	2 220	2 167
Хан-Уул	1 778	1 949	1 966	2 160	2 181
Чингэлтэй	1 226	1 302	1 142	1 215	1 116

* урьдчилсан гүйцэтгэл

ЗУРАГ 4.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, дүүргээр, 2025 он



Аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 1398 (22.6%) хувийг Баянзүрх дүүрэг, 1131 (18.3%) хувийг Баянгол дүүрэг, 1069 (17.3%) хувийг Хан-Уул дүүрэг, 1005 (16.3%) хувийг Сүхбаатар

дүүрэг хамгийн олон ААНБ байна. Үлдсэн 1565 (25.5%) хувийг Багануур, Багахангай, Налайх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүд эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарт ажиллагчид

Нийслэлийн хэмжээнд 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоо 2025 оны байдлаар 637.8 мянга байгаагийн 131.0 (20.6%) мянга нь аж үйлдвэрийн салбарт ажиллаж байна. Аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын 82.7 (63.1%) мянга нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 37.6 (28.7%) мянга нь уул уурхай, олборлолтын салбарт, 7.2 (5.5%) мянга нь цахилгаан, хий, уур агааржуулалтын салбарт, 3.5 (2.7%) мянга нь ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарт ажиллаж байна.

Аж үйлдвэрийн салбарт ажиллаж буй нийт ажиллагчдын 48.6 (37.1%) мянга нь эмэгтэйчүүд байна. Эмэгтэй ажиллагчдын 41.0 (84.3%) мянга нь боловсруулах үйлдвэрлэл, 5.6 (11.6%) мянга нь уул уурхай, олборлолт, 0.7 (1.4%) мянга нь ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, 1.3 (2.7%) мянга нь цахилгаан, хий, уур агааржуулалтын салбарт ажиллаж байна.


Аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын тоог дэд салбараар өмнөх онтой харьцуулахад уул уурхай, олборлолтын салбарын ажиллагчдын тоо 13.9 (12.7%) мянга, ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл

ажиллагааны салбарын ажиллагчдын тоо 0.2 (6.9%) мянга, боловсруулах үйлдвэрийн салбарын ажиллагчдын тоо өмнөх оноос 9.3 (12.7%) мянгаар өссөн бол цахилгаан, хий, уур агааржуулалтын салбарын ажиллагчдын тоо 2.6 (26.4%) мянгаар буурчээ.

* урьдчилсан гүйцэтгэл

ЗУРАГ 5.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧИД, дэд




салбар

Аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын тоог аймгаар авч үзвэл, 2025 онд 637.8 (47.0%) мянга нь Улаанбаатар, 33.6 (2.5%) мянга нь Орхон, 58.4 (4.3) мянга нь Хөвсгөл, 35.7 (2.6%)

мянга нь Дархан-Уул, 42.4 (3.1%) мянга нь Архангай, 38.5 (2.8%) мянга нь Сэлэнгэ, 57.3 (4.2%) мянга нь Өвөрхангай, үлдсэн 455.3 (33.5%) мянга нь бусад аймагт ажиллаж байна.

ЗУРАГ 6.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧДЫН ТОО, аймаг, нийслэлээр, 2025 он, мянган хүнээр



* урьдчилсан гүйцэтгэл

ХҮСНЭГТ 2.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧИД, дэд салбар, насны бүлгээр, 2025 он

Насны бүлгээр	Аж үйлдвэрийн дэд салбар			
	Боловсруулах үйлдвэрлэл	Уул уурхай, олборлолт	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа
	Мянган хүн			
15-19	948	290	-	125
20-24	6 274	2 497	705	206
25-29	11 857	6 443	902	152
30-34	11 726	7 792	155	384
35-39	11 365	7 624	1 514	392
40-44	13 497	5 842	1 916	657
45-49	11 630	3 366	1 269	263
50-54	6 888	1 341	322	617
55-59	4 367	1 384	449	723
60-64	2 846	496	-	-
65-69	839	532	-	-
70+	478	-	-	-
Нийслэлийн дүн	82 715	37607	7 232	3 519

2025 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийн хэмжээнд ажиллагчдыг насны бүлгээр авч үзвэл 25-29 насныхан боловсруулах салбарт, 30-34 насныхан уул уурхай, олборлолтын салбарт, 40-44 насныхан

цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарт, 55-59 насныхан усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт хамгийн олон ажиллагчид байна.

ЗУРАГ 7.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧИД, дэд салбар, жил бүрийн эцэст



Аж үйлдвэрийн салбарын ажиллагчдыг дэд салбаруудыг өмнөх онтой харьцуулахад боловсруулах үйлдвэрлэл 9316 (12.7%), уул уурхай, олборлолт 13886 (58.5%), усан

хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбар тус тус өссөн бай

* урьдчилсан гүйцэтгэл

ХҮСНЭГТ 3.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧИД, дэд салбар, хүйсээр, жил бүрийн эцэст

Аж үйлдвэрийн дэд салбар	2024		2025*	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
	Хүн			
Боловсруулах үйлдвэрлэл	43 776	29 623	41 672	41 043
15-19	304	96	427	521
20-24	5 332	2 743	3 810	2 464
25-29	10 069	2 882	8 261	3 596
30-34	6 216	4 858	7 186	4 540
35-39	6 819	2 720	6 045	5 320
40-44	4 809	4 126	5 410	8 087
45-49	6 009	5 249	4 136	7 494
50-54	2 122	3 250	3 305	3 583
55-59	1 153	1 539	1 198	3 169
60-64	778	2 102	1 468	1 378
65-69	165	58	426	413
70+	-	-	-	478
Уул уурхай, олборлолт	21 508	2 214	31 984	5 624
15-19	-	-	290	-
20-24	3 364	74	2 339	158
25-29	1 809	-	5 170	1 273
30-34	4 253	391	6 604	1 188
35-39	5 657	1 073	6 901	723
40-44	1 820	263	5 446	395
45-49	2 370	413	2 603	764
50-54	793	-	499	843
55-59	1 068	-	1 104	280
60-64	374	-	496	-
65-69	-	-	532	-
70+	-	-	-	-
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	7 961	1 863	5 906	1 326
15-19	228	-	-	-
20-24	382	-	705	-
25-29	1 235	-	724	177
30-34	499	64	155	-
35-39	1 187	677	1 261	253
40-44	1 063	161	1 435	482
45-49	2 014	70	1 098	171
50-54	298	419	234	88
55-59	1 055	29	294	155
60-64	-	-	-	-
65-69	-	443	-	-
70+	-	-	-	-
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	900	2 392	2 852	666
15-19	-	-	125	-
20-24	-	-	206	-
25-29	311	555	152	-
30-34	497	306	330	53
35-39	-	274	392	-
40-44	92	351	312	345
45-49	-	-	127	136
50-54	906	906	485	132
55-59	-	-	723	-
60-64	-	-	-	-
65-69	-	-	-	-
70+	-	-	-	-

* урьдчилсан гүйцэтгэл

I.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 30.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 8.9 (41.7%) их наяд төгрөгөөр өсжээ. Өсөлтийг дэд салбараар авч үзвэл, уул уурхай, олборлолтын салбарынх 20.9 их наяд төгрөг болж, 7.5 (56.5%) их наяд төгрөгөөр, боловсруулах салбарынх 6.8 их наяд төгрөг болж, 760.1

(12.7%) тэрбум төгрөгөөр, цахилгаан, хий, агааржуулалтын салбарынх 2.5 их наяд төгрөг болж, 604.5 (32.4%) тэрбум төгрөгөөр, ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарынх 206.7 тэрбум төгрөг болж, 16.1 (8.4%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


ХҮСНЭГТ 4. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар

Салбар	2021	2022	2023	2024	2025*	Өөрчлөлт	
	тэрбум төгрөг					Дүн	Хувь
Нийт дүн	10 964.3	13 466.8	18 495.2	21 415.9	30 342.6	8 926.7	41.7
Уул уурхай, олборлолт	6 145.3	7 686.1	10 874.5	13 358.3	20 904.4	7 546.0	56.5
Боловсруулах үйлдвэрлэл	3 442.7	4 299.8	5 756.1	6 003.1	6 763.2	760.1	12.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1 249.7	1 338.2	1 708.9	1 863.8	2 468.3	604.5	32.4
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах	126.6	142.7	155.7	190.7	206.7	16.1	8.4

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлд уул уурхай, олборлолтын салбарын үйлдвэрлэл 68.9 хувийг, боловсруулах үйлдвэрлэлийн салбарынх 22.3 хувийг, цахилгаан хий, уур, агааржуулалтын

салбарынх 8.1 хувийг, ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарынх 0.7 хувийг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 8. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БҮТЭЦ, дэд салбараар



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн бүтцийг өмнөх онтой харьцуулахад боловсруулах үйлдвэрлэлийн салбар 5.7 нэгж хувиар, цахилгаан, хий, уур агааржуулалтын салбар 0.6 нэгж хувиар, ус хангамж;

сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар 0.2 нэгж хувиар тус тус буурсан бол уул уурхай, олборлолтын салбар 6.5 нэгж хувиар өссөн байна.

* урьдчилсан гүйцэтгэл

1.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛАЛТ

Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалт 2025 онд 36.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 12.2 (51.1%) их наяд төгрөгөөр өссөн байна. Үүнд уул уурхайн салбарын борлуулалт 25.0 их наяд төгрөг болж, 10.4 (71.9%) их наяд төгрөгөөр, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын борлуулалт 8.4 их наяд төгрөг болж, 1.1 (5.0%) их наяд төгрөгөөр, цахилгаан, хий, уур агааржуулалтын салбарын борлуулалт 2,5

их наяд төгрөг болж, 604.1 (32.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалтын 69.3 хувийг уул уурхай, олборлолтын салбар, 23.3 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 6.8 хувийг цахилгаан, хий, уур агааржуулалтын салбар, 0.6 хувийг ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар эзэлж байна.

ХҮСНЭГТ 5. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛАЛТ, дэд салбараар

Салбар	2021	2022	2023	2024	2025*	Өөрчлөлт	
	тэрбум төгрөг					Дүн	Хувь
Нийт дүн	15 847.9	15 928.4	20 847.9	23 831.6	36 020.1	12 188.4	51.1
Уул уурхай, олборлолт	10 243.1	9 073.6	12 123.0	14 515.5	24 958.3	10 442.9	71.9
Боловсруулах үйлдвэрлэл	4 226.7	5 372.7	6 856.0	7 257.0	8 388.3	1 131.3	15.6
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1 249.7	1 338.3	1 709.2	1 864.2	2 468.3	604.1	32.4
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах	128.4	143.8	159.7	194.9	205.2	10.3	5.3




Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалтын 65.0 хувийг гадаадад борлуулсан бүтээгдэхүүн эзэлж байна. Гадаадын борлуулалт 2025 онд 23.4 их наяд төгрөг байгаагийн 21.8 (93.2%) их

наяд төгрөгийг уул уурхай, олборлолтын салбарын борлуулалт, 1.6 (6.8%) их наяд төгрөгийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарын борлуулалт эзэлж байна.

* урьдчилсан гүйцэтгэл

ЗУРАГ 9.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БОРЛУУЛАЛТ, дүүргээр, 2025 он



Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалт 36.0 их наяд төгрөг хүрч, 19.0 (65.0%) их наяд төгрөгийг гадаад борлуулалт эзэлж байна.

Нийт борлуулалтаар нь авч үзвэл 20.7 (57.5%) их наяд төгрөгийг Сүхбаатар дүүрэг, үүнээс 19.0 (81.1%) их наяд төгрөгийн гадаад борлуулалт хийсэн байна. Багахангай дүүрэгт 1.9 тэрбум төгрөгийн нийт борлуулалт хийсэн нь бусад дүүрэгтэй харьцуулахад хамгийн бага байна.

* урьдчилсан гүйцэтгэл

II. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ

Уул уурхай, олборлолтын салбар нь аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлтийн 68.9 хувийг, нийт борлуулалтын 69.3 хувийг эзэлж байгаа томоохон салбар юм.

Уул уурхай, олборлолтын салбарын нийт үйлдвэрлэл 2025 онд 30.3 их наяд төгрөг болж, өмнөх оноос 8.9 (41.7%) их наяд төгрөгөөр, нийт борлуулалт 36.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 12.2 (51.1%) их наяд төгрөгөөр өссөн байна.

II.1 НҮҮРС ОЛБОРЛОЛТ

Нүүрс олборлолтын салбарт 2025 онд 2.7 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 1.3 (31.8%) их наяд төгрөгөөр буурсан байна.

Нүүрс олборлолтын салбарын үйлдвэрлэл 2025 онд аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 8.9 хувийг, уул уурхай, олборлолтын салбарын 13.0 хувийг эзэлж, өмнөх оноос 5.6 нэгж хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 6.

НҮҮРС ОЛБОРЛОЛТЫН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ


Салбар	2021	2022	2023	2024	2025*
	тэрбум төгрөг				
Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл	10 964.3	13 466.8	18 495.2	21 415.9	30 342.6
Уул уурхай, олборлолт	6 145.3	7 686.1	10 874.5	13 358.3	20 904.4
Нүүрс олборлолт	435.9	522.1	2 401.4	3 976.9	2 712.7
Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд нүүрс олборлолтын салбарын эзлэх хувь	4.0	3.9	13.0	18.6	8.9
Уул уурхай, олборлолтод нүүрс олборлолтын салбарын эзлэх хувь	7.1	6.8	22.1	18.6	13.0

Нийслэлийн хэмжээнд 2025 онд 21.0 сая тонн нүүрс олборлосон нь өмнөх оноос 0.7 (3.5%) сая тонноор буурсан байна.

Нийт олборлосон нүүрсний 74.1 хувийг чулуун нүүрс, 25.9 хувийг хүрэн нүүрс эзэлж байна.

ЗУРАГ 10.

ХҮРЭН, ЧУЛУУН НҮҮРСНИЙ ОЛБОРЛОЛТ



* урьдчилсан гүйцэтгэл

II.2 ГАЗРЫН ТОС ОЛБОРЛОЛТ

Газрын тос олборлолтын салбарт 2025 онд 1.1 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 183.9 (14.1%) тэрбум төгрөгөөр буурчээ. Газрын тос олборлолтын салбар 2024 онд нийт аж үйлдвэрийн салбарын 2.2 хувийг

эзэлж, эзлэх хувь өмнөх оноос 1.1 нэгж хувиар, уул уурхай, олборлолтын салбарт эзлэх хувь 2.8 хувь болж, өмнөх оноос 1.5 нэгж хувиар тус тус буурчээ.

ХҮСНЭГТ 7. ГАЗРЫН ТОС ОЛБОРЛОЛТЫН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

Салбар	2021	2022	2023	2024	2025*
	тэрбум төгрөг				
Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл	10 964.3	13 466.8	18 495.2	21 415.9	30 342.6
Уул уурхай, олборлолт	6 145.3	7 686.1	10 874.5	13 358.3	20 904.4
Газрын тос олборлолт	902.2	776.1	1 305.9	1 122.1	951.4
Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд нүүрс олборлолтын салбарын эзлэх хувь	8.2	5.8	7.1	5.2	3.1
Уул уурхай, олборлолтод нүүрс олборлолтын салбарын эзлэх хувь	14.7	10.1	12.0	8.4	4.6

II.3 БУСАД АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЛТ

Нийслэлийн хэмжээнд 2025 онд хайлуур жонш 1036.7 тонн, хайлуур жоншны баяжмал 205.4 тонныг тус тус олборложээ. Уул уурхайн

бүтээгдэхүүний олборлолтыг өмнөх онтой харьцуулахад хайлуур жонш 293.8 (39.5%), хайлуур жоншны баяжмал 68.3 (49.8%) тонноор тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 8. БУСАД АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЛТ

Ашигт малтмалын төрөл	2021	2022	2023	2024	2025*	Өөрчлөлт	
	тонн					Дүн	Хувь
Хайлуур жонш	458.8	235.2	585.1	742.9	1 036.7	293.8	39.5
Хайлуур жоншны баяжмал	105.2	85.6	208.9	137.1	205.4	68.3	49.8
Төмрийн хүдэр	261.8	0.001	0.463	1.0	-	-1.0	I
Төмрийн хүдрийн баяжмал	-	2.3	1.9	14.9	-	-14.9	I

* урьдчилсан гүйцэтгэл

I харьцуулагдахгүй

III. БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ

Боловсруулах салбарын үйлдвэрлэл 2025 оны байдлаар 6.8 их наяд төгрөг болж, өмнөх оноос 760.1 (12.7%) тэрбум төгрөгөөр, борлуулалт 8.4 их наяд төгрөг болж, 1131.3 (15.6%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Боловсруулах салбарын үйлдвэрлэлийг дэд салбараар авч

үзвэл, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл 36.2 хувийг, ундаа үйлдвэрлэл 17.5 хувийг, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл 4.2 хувийг, нэхмэлийн үйлдвэрлэл 14.8 хувийг, хувцас үйлдвэрлэл 6.6 хувийг, бусад салбар 20.7 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 9.

БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН БҮТЭЦ, дэд салбар

Дэд салбар	2021	2022	2023	2024	2025*
	хувь				
Нийт дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	33.0	29.2	34.3	33.4	36.2
Ундааны үйлдвэрлэл	19.1	19.8	16.8	18.6	17.5
Тамхины үйлдвэрлэл	2.2	1.3	1.2	0.9	0.6
Нэхмэлийн үйлдвэрлэл	14.6	18.4	15.6	15.0	14.8
Хувцас үйлдвэрлэл	4.9	5.2	4.2	3.8	6.6
Хэвлэх, дуу бичлэгийн хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	1.2	1.4	1.0	1.1	0.8
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	4.0	5.3	4.3	4.5	4.2
Бусад	21.0	19.4	22.6	22.7	19.3

III.1 ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН, УНДАА ҮЙЛДВЭРЛЭЛ

Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2025 онд 2.8 их наяд төгрөг болж, өмнөх оноос 438.2 (21.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

